



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2014 оны 06 сарын 03 өдөр

Дугаар 4/219

Сүхбаатар


**“Ээлтэй үйлчилгээ-Иргэн танд” арга хэмжээг
зохион байгуулах тухай**

“Аймгийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.1.10 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн “а”, “г”, “е” заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 12 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2014 оныг аймгаас “Ээлтэй орчин, их бүтээн байгуулалтын жил” болгон зарласантай холбогдуулан энэ жилийн “Нээлттэй хаалганы өдөр” арга хэмжээг “Ээлтэй үйлчилгээ-Иргэн танд” уриан дор 2014 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс 23-ны өдрүүдэд нийт сум, тосгодод зохион байгуулсугай.


2.Тус арга хэмжээнд шаардагдах 25.0 сая төгрөгийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлагдсан төсвийн дагуу холбогдох зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /А.Сарантуяа/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



С.БҮРЭНБАТ

Сэлэнгэ аймгийн Засаг даргын
2014 оны 6 -р сарын 23-ны
өдрийн 4/219 тоот захирамжийн
хавсралт



**2014 ОНЫ 06-Р САРЫН 02-23-НЫ ӨДРҮҮДЭД НИЙТ СУМД, ТОСГОДОД ЗОХИОН
БАЙГУУЛАХ “ЭЭЛТЭЙ ҮЙЛЧИЛГЭЭ-ИРГЭН ТАНД” АРГА ХЭМЖЭЭНИЙ
ЗАРДЛЫН НЭГДСЭН ТӨСӨВ**

2014.05.30

| № | Зардал | Тоо/Км | Хугацаа /хоног/ | Нэг бүрийн үнэ | Бүгд үнэ /төг/ | Тайлбар |
|-------------|-------------------------------------|--------|--------------------|----------------------|-------------------|---------|
| 1 | Томилолт | 55 | 22 | 6700 | 8107000 | |
| 2 | Хоол | 55 | 22 | 7550 | 9135500 | |
| 3 | Шатахуун | | | | 5048100 | |
| | 0001 СЭА | 2225 | 22 | 1690 | 827300 | |
| | ЗД хөдөөгүүр | 1000 | 22 | 1690 | 371800 | |
| | 0003 СЭА | 700 | 22 | 1690 | 260300 | |
| | 0010 СЭА | 2805 | 16 | 1690 | 758500 | |
| | 0011 СЭА | 2805 | 22 | 1820 | 1123200 | |
| | Эмнэлгийн фургон | 2925 | 19 | 1590 | 853500 | |
| | Эмнэлгийн фургон | 2925 | 19 | 1590 | 853500 | |
| 4 | Анонс | 2 | | | 302500 | |
| 5 | Эмчийн замын зардал | | | | 140000 | |
| | Ерөө-СБ-Ерөө | 2 | | 10000 | 40000 | |
| | Сайхан-СБ-Сайхан | 2 | | 25000 | 100000 | |
| 6 | Эмнэлгийн үйл ажиллагааны зардал | 1 | - | - | 2266705 | |
| НИЙТ | | | | | 24999805 | |

Төсөв гаргасан:

МХШҮА-ны мэргэжилтэн

Б.Болорзул



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2014 оны 05 сарын 06 өдөр

Дугаар А/168

Сүхбаатар

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 1-ийн 3-ын "л", Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлиг, аймгийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.2.5 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Ногоон-Сэлэнгэ" хөдөлгөөнийг аймгийн хэмжээнд 2014 оны 04 дүгээр 01-ний өдрөөс 2014 оны 10 дугаар сарын 25-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2."Ногоон-Сэлэнгэ" хөдөлгөөнийг зохион байгуулах аймгийн ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:

Н.Батдорж

-Аймгийн Засаг даргын орлогч

Гишүүдэд:

С.Отгонжаргал

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга

Ч.Дэмбэрэлсайхан

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга

Ж.Батсайхан

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга

Б.Батзориг

-Аймгийн Байгаль орчны газрын дарга

Д.Батдэлгэр

-Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга

Б.Баттулга

-Аймгийн Соёл, спорт, аялал жуулчлалын газрын дарга

Д.Загдгочоо

-Аймгийн Боловсролын газрын дарга

Б.Мөнхбат

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын

Хөгжлийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн

Г.Цэнгэлзаяа

-Аймгийн Байгаль орчны газрын ахлах мэргэжилтэн

3."Ногоон-Сэлэнгэ" хөдөлгөөний хүрээнд хийх ажлын төлөвлөгөөг нарийвчлан гаргаж, хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган дэмжлэг туслалцаа үзүүлж, явцын хяналт тавьж ажиллан үр дүнгийн мэдээллийг аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Н.Батдорж/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С.БҮРЭНБАТ